



НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/06


Улаанбаатар хот

Албан тушаалын тодорхойлолт
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 дүгээр тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт батлах нийтлэг журам”, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын Дүрэм, бүтэц зохион байгуулалт шинэчлэн батлах тухай А/11 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1.Тус төвийн албан тушаалын тодорхойлолт шинэчлэх албан тушаалын нэрсийг нэгдүгээр, албан тушаалын тодорхойлолтыг хоёрдугаар хавсралтаар шинэчлэн баталж, 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж ажилласугай.
- 2.Албан тушаалын тодорхойлолтод заасны дагуу чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг албан хаагчдад үүрэг болгосугай.
- 3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт хариуцсан орлогч дарга (П.Сувд)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.АРИУНБОЛД

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН НЭРС 10/7032

1. Тусламж үйлчилгээ хариуцсан орлогч дарга
2. Захиргаа, төлөвлөлт хариуцсан орлогч дарга
3. Хүний нөөцийн албаны дарга
4. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын, албаны дарга
5. Санхүү бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч
6. Хөдөлмөр, аюулгүй байдал хариуцсан ажилтан
7. Сургалтын ажилтан
8. Хүний нөөцийн менежер
9. Архивын эрхлэгч
10. Эрсдэлийн менежер
11. Чанарын менежер
12. Программ хангамжийн инженер
13. Мэдээлэл технологи, сүлжээний инженер
14. Дүн бүртгэлийн ажилтан
15. Эрүүл мэндийн даатгалын мэргэжилтэн
16. Эдийн засагч
17. Үндсэн хөрөнгийн нягтлан бодогч
18. Цалингийн нягтлан бодогч
19. Шатахуун, тос тослох материалын нягтлан бодогч
20. Эм, эмнэлгийн хэрэгслийн нягтлан бодогч
21. Аж ахуйн нярав
22. Сэлбэгийн нярав
23. Ашиглалтын инженер
24. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер
25. Шалгах механик
26. Засварын механик
27. Баазын диспетчер
28. Аж ахуйн менежер
29. Сантехникч
30. Цахилгаанчин
31. Мужаан
32. Үйлчлэгч
33. Угаагч
34. Эмийн сан, сувилахуй хариуцсан ажилтан
35. Халдвар судлаач
36. Салбар хариуцсан дарга
37. Ээлжийн ахлах эмч
38. Оператор сувилагч
39. Дуудлагын сувилагч
40. Эмийн сангийн сувилагч
41. Дуудлагын эмч
42. Дуудлагын жолооч
43. Засварчин
44. Оператор эмч
45. Техникийн тоо бүртгэгч

- 46. Эмийн сангийн ариутгагч
- 47. Дотоод хяналтын ажилтан
- 48. Хоолны технологич
- 49. Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн
- 50. Сургалт, гадаад харилцааны албаны дарга
- 51. Даатгал, статистик мэдээллийн албаны дарга
- 52. Аж ахуйн албаны дарга
- 53. Даргын туслах, бичиг хэрэг ажилтан